



ХЭРЛЭН СУМЫН 2024 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг 4 дэд салбар бодлогын хүрээнд, 11 зорилт, нийт 116 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс үүнээс хэрэгжих боломжгүй 4, төсвийн тодотголоор хасагдсан 8, хэрэгжсэн 104 ажил, арга хэмжээ байна.

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД: */ 6 зорилт, 28 арга хэмжээ/*

Ерөнхий боловсролын сургуулиудын ширээ, сандлыг шинэчлэх, сургуулийн спорт заалыг засварлах, тоног төхөөрөмжийг сайжруулах, зорилтот бүлгийн өсвөр насны хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, сургалт зохион байгуулах төрийн албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоод хамруулах, хүүхэд, залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх тоглоомын талбайг нэмэгдүүлэх, дасгал хөдөлгөөнөөр дамжуулан эрүүлжих, угийн бичиг хөтлөлтийн ач холбогдлыг түгээн дэлгэрүүлэх, соёл урлагийг дэмжих, сэтгэл зүй зан хандлагад нөлөөлөх сургалт арга хэмжээ зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настныг дэмжих чиглэлээр нийт 28 ажил, арга хэмжээ зохион байгуулсан.

Биелэлт: 90.3 хувь

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ БОДЛОГЫН ХҮРЭЭНД. /1 зорилт, 18 арга хэмжээ/

Арван мянган хүлэмж төсөлд иргэн, аж ахуйн нэгжийг хамруулах, хөдөө аж ахуйг дэмжих чиглэлийн төсөл хөтөлбөрт хамруулах, малын сэг зэм устгах, гүний худаг гаргах, малчдад зориулан өвс, тэжээл авах, статистик судалгаа гаргах, аялал жуулчлалын хөгжүүлэх чиглэлээр гадна, дотны байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд нийт 18 ажил, арга хэмжээг зохион байгуулсан.

Биелэлт: 90 хувь

Үнэлэх боломжгүй: 1 ажил

**ГУРАВ. НОГООН ХӨГЖИЛ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:
/1 зорилт, 12 ажил, арга хэмжээ/**

Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хот орчмын эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийх, бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах, байгаль орчныг хамгаалах чиглэлээр ерөнхий боловсролын сургууль, иргэдэд сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, хог хаягдлыг бууруулах чиглэлээр автомашин, шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах хүрээнд нийт 12 ажил гүйцэтгэсэн.

Биелэлт: 90 хувь

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:
/ 3 зорилт, 58 ажил, арга хэмжээ/

Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хот орчмын эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийх, бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах, байгаль орчныг хамгаалах чиглэлээр ерөнхий боловсролын сургуулиуд, иргэдэд сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, хог хаягдлыг бууруулах чиглэлээр автомашин, шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах хүрээнд нийт 12 ажил гүйцэтгэсэн.

Биелэлт: 90 хувь

Мөн батлан хамгаалах, гамшгаас хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, Хамтарсан багийн үйл ажиллагааг чадавхжуулах, архидан согтуурахтай тэмцэх арга хэмжээг зохион байгуулах, ЕБС-ийн замын гарц тэмдэглэгээг шинэчлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, орон сууцны байруудын хаалгыг шинэчлэх нийт 58 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан ба төсвийн тодотголоор хасагдсан 7, үнэлэх боломжгүй 2 ажил байна.

Биелэлт: 86.2

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**